



ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Тендерийн үнэлгээний хороо байгуулах

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Компанийн 4 болон 5 давхарын өрөө, тасалгаанд өөрчлөлт хийх, барилгын урсгал засвар хийх ажлыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Т.Оюун-Эрдэнэ Системийн хэтийн төлөвлөлт судалгааны инженер

Нарийн бичгийн дарга:

Н.Бат-Өлзий ХМС-ийн программын инженер

Гишүүн: Д.Амармөнх Хуулийн мэргэжилтэн бөгөөд захирлын туслах

2. Тендерийн сонгон шалгаруулалтыг хууль, тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулж, тендерийн үнэлгээний дүгнэлт гаргаж танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга /Т.Оюун-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал /Ц.Эрдэнэбулган/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х. ЦОГТБААТАР